ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

---

**Алтай сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

**Аудитын код:** ГАА-2022/04/-НА-СТА-ТШЗ


| | | |
|---|---|---|
| | Дарга, Тэргүүлэх аудитор: | Х.Түвшинбаяр |
| | Утас: 70483413 | Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn |
| | Аудитын менежер: | Д.Эрдэнэчимэг |
| **Цахим хуудас:** www.audit.mn | Утас: 70484055 | Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn |
| Алтай хот | Ахлах аудитор: | Ж.Бужинханд |
| 2022 он | Утас: 99177546 | Цахим хаяг: Bujinkhandj@audit.gov.mn |
| | Аудитор<br>Утас: 70484030 | Г.Энхдэлгэр<br>Цахим хаяг: Enkhdelgerg@audit.gov.mn |


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

1. Аудитын санал дүгнэлт ....... **Error! Bookmark not defined.**
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл ....... 4
3. Аудитын тайлан ....... 9
3.1 Ерөнхий зүйл ....... 9
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт ....... 10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ....... 10
3.4 Материаллаг байдал ....... 10
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга ....... 11
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв ....... 11
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг ....... 12
3.8 Аудитын гол асуудал ....... 12
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ....... 12
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ....... 12
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал ....... 12
4. Аудитын илрүүлэлт ....... 13
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл ....... 14

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |
| ЗДТГ | Засаг даргын тамгын газар |

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
9018301, Говь-Алтай аймаг,
Есөнбулаг сум, 7-р баг, Жинст 0
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13,
E –mail: govialtai@audit.gov.mn

2022.02.24 № 60

танай ______ -ны № ______ -т

АЛТАЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА
Н.БАТБАЯР ТАНАА

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Алтай сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Алтай сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Гэрээний хугацаа дууссан байхад 11 толгой малыг дараагийн малчин өрхөд хүлээлгэн өгөөгүй, түлш халаалтын зардлаас бэлтгэсэн нүүрснээс ажилчдад түлшний хөнгөлөлтөөр олгосон, хамтын сангийн хуримтлалд зориулж ажилчдын цалингаас суутгал хийсэн, татварын тодорхойлолтоор зөрүү тооцоо татварын цахим системд бүртгэлтэй, жилийн эцсийн тооллогоор хөрөнгийг бүрэн тоолж баталгаажуулаагүй зэрэг 521.8 сая төгрөгийн зөрчил нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12.1, Малчидтай байгуулсан малжуулах гэрээ, Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаал "Эдийн засгийн ангилал ашиглах заавар", Хөдөлмөрийн тухай хуулийн 119 дүгээр зүйлийн 119.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72.4 дэх заалт, АДБОУС 1250, 1300, MNS-6817-4:2020 стандартын 7.1.2.2, 7.1.3.4 заалттай нийцэхгүй бөгөөд нийцсэн бөгөөд зохистой батламж мэдэглийг хангахгүй.

07000340

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Х.ТҮВШИНБАЯР

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Код | Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | 408,688,291.89 | 379,407,670.19 |
| **33** | **АВЛАГА** | 40,008,200.00 | 40,000,000.00 |
| **33500** | **Бусад авлага** | 40,008,200.00 | 40,000,000.00 |
| 33510 | Байгууллагаас авах авлага | 40,000,000.00 | 40,000,000.00 |
| 33520 | Хувь хүмүүсээс авах авлага | 8,200.00 | - |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 368,680,091.89 | 339,407,670.19 |
| **35100** | **Түүхий эд материал** | 37,000,002.00 | 37,000,002.00 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 37,000,002.00 | 37,000,002.00 |
| **35400** | **Хангамжийн материал** | 107,003,529.89 | 77,731,108.19 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 387,000.00 | 387,000.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 2,142,000.00 | 3,251,000.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 104,474,529.89 | 74,093,108.19 |
| 35600 | Мал амьтад | 224,676,560.00 | 224,676,560.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | 1,790,400,144.06 | 1,821,201,429.47 |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 1,790,400,144.06 | 1,821,201,429.47 |
| **39200** | **Биет хөрөнгө** | 1,705,813,144.39 | 1,737,255,429.47 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 1,641,101,743.00 | 1,795,571,122.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (185,341,384.35) | (268,265,723.87) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 311,781,360.00 | 325,681,360.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (230,293,995.16) | (255,574,844.10) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж(компьютер) | 148,115,229.00 | 143,694,329.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (106,356,013.20) | (90,813,349.59) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 97,719,776.77 | 97,734,086.77 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (46,159,468.11) | (49,979,250.74) |
| 39209 | Зам, гүүрийн байгууламж | 51,273,480.00 | - |
| 39210 | Хуримтлагдсан элэгдэл | (155,283.56) | - |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 24,127,700.00 | 39,207,700.00 |
| **39300** | **Биет бус хөрөнгө** | 84,586,999.67 | 83,946,000.00 |
| 39301 | Програм хангамж | 740,000.00 | 3,435,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (707,333.52) | (3,435,000.00) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 86,641,000.00 | 83,946,000.00 |
| 39304 | Хуримтлагдсан элэгдэл | (2,086,666.81) | - |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | 2,199,088,435.95 | 2,200,609,099.66 |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | - | - |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | 2,199,088,435.95 | 2,200,609,099.66 |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 2,199,088,435.95 | 2,200,609,099.66 |
| 51100 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон | 296,189,424.37 | 296,189,424.37 |
| **51200** | **Хуримтлагдсан үр дүн** | 1,900,791,894.68 | 1,902,312,558.39 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 791,799,045.79 | 1,900,791,894.68 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 1,108,992,848.89 | 1,520,663.71 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 2,107,116.90 | 2,107,116.90 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | 2,199,088,435.95 | 2,200,609,099.66 |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Код | Үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|---|---|---|---|
| I | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | 1,613,324,958.58 | 544,269,610.00 |
| 12 | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | 1,229,025,252.58 | 173,634,427.00 |
| 120 | **Нийтлэг татварын бус орлого** | 1,229,025,252.58 | 173,634,427.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 1,229,025,252.58 | - |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 1,229,025,252.58 | - |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | - | 167,395,899.00 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал | - | 6,238,528.00 |
| 13 | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | 384,299,706.00 | 370,635,183.00 |
| 1311 | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 59,279,406.00 | 12,331,783.00 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, | 6,930,000.00 | 6,970,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод | 51,438,406.00 | 5,361,783.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий | 911,000.00 | - |
| 1320 | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 325,020,300.00 | 358,303,400.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт | 325,020,300.00 | 358,303,400.00 |
| II | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | 504,332,109.69 | 529,249,587.70 |
| 21 | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 504,332,109.69 | 529,249,587.70 |
| 210 | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 502,814,922.69 | 529,112,815.93 |
| 2101 | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 224,097,624.62 | 227,608,627.00 |
| 210101 | Үндсэн цалин | 147,581,400.00 | 168,116,525.00 |
| 210102 | Нэмэгдэл | 19,021,557.00 | 31,555,914.00 |
| 210104 | Урамшуулал | 41,563,867.62 | 27,936,188.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 15,930,800.00 | - |
| 2102 | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 27,715,400.00 | 29,634,226.23 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 19,529,800.00 | 20,299,967.55 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,246,300.00 | 2,247,989.67 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,763,000.02 | 1,798,391.74 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 449,599.98 | 449,597.93 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 3,726,700.00 | 4,838,279.34 |
| 2103 | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 23,731,006.00 | 16,515,886.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,174,306.00 | 3,407,886.00 |
| 210302 | Түлш, халаалт | 21,476,700.00 | 13,028,000.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 80,000.00 | 80,000.00 |
| 2104 | **Хангамж, бараа материалын зардал** | 90,319,034.29 | 83,301,589.70 |
| 210401 | Бичиг хэрэг | 2,496,500.00 | 3,543,950.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 68,717,520.00 | 40,835,998.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 3,113,700.00 | 827,420.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 150,000.00 | 6,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,015,514.29 | 2,591,800.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 14,825,800.00 | 35,496,421.70 |
| 2105 | **Норматив зардал** | 1,900,000.00 | 800,050.00 |
| 210502 | Хоол, хүнс | 1,150,000.00 | 500,050.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 750,000.00 | 300,000.00 |
| 2106 | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 842,000.00 | 1,654,200.00 |
| 210602 | Тавилга | 42,000.00 | - |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл | - | 60,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 800,000.00 | 1,594,200.00 |
| 2107 | **Томилолт, зочны зардал** | 5,206,000.00 | 5,987,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 5,206,000.00 | 5,987,000.00 |
| 2108 | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 32,865,224.00 | 32,417,482.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр | 31,399,824.00 | 31,952,062.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 480,000.00 | - |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 252,000.00 | - |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 120,000.00 | 116,188.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 141,400.00 | 108,900.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 400,000.00 | 220,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 72,000.00 | 20,332.00 |
| 2109 | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 96,138,633.78 | 131,193,755.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1,725,000.00 | 4,498,500.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 420,000.00 | - |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 93,993,633.78 | 126,695,255.00 |
| 213 | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 1,517,187.00 | 136,771.77 |
| 2132 | **Бусад урсгал шилжүүлэг** | 300,000.00 | - |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 300,000.00 | - |
| 2134 | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас,** | 1,217,187.00 | 136,771.77 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 890,187.00 | 136,673.77 |
| 213405 | Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг | 327,000.00 | 98.00 |
| III | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)** | 1,108,992,848.89 | 15,020,022.30 |
| IV | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН** | - | - |
| V | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | - | 13,499,358.59 |
| 225001 | Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз | - | 13,499,358.59 |
| VI | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)** | 1,108,992,848.89 | 1,520,663.71 |
| VI-I | Засгийн газрын хувь оролцоо | - | - |
| VI-II | Хяналтын бус хувь оролцоо | - | - |



Говь-Алтай аймаг дахь ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

## 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| 1 | **2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 296,189,424.37 | 2,107,116.90 | 791,799,044.80 | 1,090,095,586.07 |
| 2 | **Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт** | - | - | 0.99 | 0.99 |
| 3 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | 296,189,424.37 | 2,107,116.90 | 791,799,045.79 | 1,090,095,587.06 |
| 9 | **Тайлант үеийн үр дүн** | - | - | 1,108,992,848.89 | 1,108,992,848.89 |
| 10 | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 296,189,424.37 | 2,107,116.90 | 1,900,791,894.68 | 2,199,088,435.95 |
| 11 | **2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | 296,189,424.37 | 2,107,116.90 | 1,900,791,894.68 | 2,199,088,435.95 |
| 12 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - |
| 13 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | 296,189,424.37 | 2,107,116.90 | 1,900,791,894.68 | 2,199,088,435.95 |
| 14 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт | - | - | - | - |
| 15 | Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт | - | - | - | - |
| 16 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | - | - | - | - |
| 17 | Өмчид гарсан өөрчилөлт | - | - | - | - |
| 18 | Зарласан ногдол ашиг | - | - | - | - |
| 19 | Тайлант үеийн үр дүн | - | - | 1,520,663.71 | 1,520,663.71 |
| 20 | **2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл** | 296,189,424.37 | 2,107,116.90 | 1,902,312,558.39 | 2,200,609,099.66 |



Говь-Алтай аймаг дахь ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Код | Үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|---|---|---|---|
| I | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)** | 384,299,706.00 | 370,635,183.00 |
| 13 | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | 384,299,706.00 | 370,635,183.00 |
| 1311 | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 59,279,406.00 | 12,331,783.00 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 6,930,000.00 | 6,970,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны | 51,438,406.00 | 5,361,783.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон | 911,000.00 | - |
| 1320 | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 325,020,300.00 | 358,303,400.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 325,020,300.00 | 358,303,400.00 |
| II | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 381,419,706.00 | 367,035,183.00 |
| 21 | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 381,419,706.00 | 367,035,183.00 |
| 210 | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 379,902,519.00 | 366,898,411.23 |
| 2101 | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 224,451,569.00 | 228,741,253.23 |
| 210101 | Үндсэн цалин | 147,581,400.00 | 151,629,253.23 |
| 210102 | Нэмэгдэл | 18,922,800.00 | 15,420,000.00 |
| 210104 | Урамшуулал | 42,016,569.00 | 30,157,200.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 15,930,800.00 | 31,534,800.00 |
| 2102 | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 27,715,400.00 | 28,501,600.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 19,529,800.00 | 19,409,900.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,246,300.00 | 2,347,900.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,763,000.00 | 1,798,300.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 449,600.00 | 449,600.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 3,726,700.00 | 4,495,900.00 |
| 2103 | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 18,144,576.00 | 18,808,486.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,445,876.00 | 2,917,486.00 |
| 210302 | Түлш, халаалт | 15,618,700.00 | 15,811,000.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 80,000.00 | 80,000.00 |
| 2104 | **Хангамж, бараа материалын зардал** | 66,187,750.00 | 45,424,990.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 2,496,500.00 | 3,400,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 59,627,750.00 | 38,430,670.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 3,113,700.00 | 827,420.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 150,000.00 | 150,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 799,800.00 | 2,616,900.00 |
| 2105 | **Нормативт зардал** | 1,900,000.00 | 800,000.00 |
| 210502 | Хоол, хүнс | 1,150,000.00 | 500,000.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 750,000.00 | 300,000.00 |
| 2106 | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 972,000.00 | 1,354,200.00 |
| 210602 | Тавилга | 172,000.00 | - |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | - | 60,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 800,000.00 | 1,294,200.00 |
| 2107 | **Томилолт, зочны зардал** | 5,206,000.00 | 5,987,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 5,206,000.00 | 5,987,000.00 |
| 2108 | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 31,234,224.00 | 32,384,482.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр | 29,768,824.00 | 31,919,062.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зөвлөгөө тогтоох | 480,000.00 | - |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 252,000.00 | - |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 120,000.00 | 116,188.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 141,400.00 | 108,900.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 400,000.00 | 220,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 72,000.00 | 20,332.00 |
| 2109 | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 4,091,000.00 | 4,896,400.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 3,591,000.00 | 4,896,400.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 500,000.00 | - |
| 213 | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 1,517,187.00 | 136,771.77 |
| 2132 | **Бусад урсгал шилжүүлэг** | 300,000.00 | - |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 300,000.00 | - |
| 2134 | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас,** | 1,217,187.00 | 136,771.77 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 890,187.00 | 136,673.77 |
| 213405 | Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг | 327,000.00 | 98.00 |
| III | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)** | 2,880,000.00 | 3,600,000.00 |
| IV | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)** | - | - |
| V | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)** | 2,880,000.00 | 3,600,000.00 |
| 22 | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | 2,880,000.00 | 3,600,000.00 |
| 2200 | **Дотоод эх үүсвэрээр** | 2,880,000.00 | 3,600,000.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 2,880,000.00 | 3,600,000.00 |
| VI | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)** | (2,880,000.00) | (3,600,000.00) |
| VIII | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)** | - | - |
| 101 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | - |
| 20 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | - |



Говь-Алтай аймаг дахь ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны Батлагдсан төлөвлөгөө | Цэвэр гүйцэтгэл |
|---|---|---|---|
| 1 | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| 2 | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **358,303,400.0** | **358,166,726.23** |
| 21 | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 358,303,400.0 | 358,166,726.2 |
| 210 | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 358,303,400.0 | 358,166,726.23 |
| 2101 | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 225,755,900.0 | 225,626,138.23 |
| 210101 | Үндсэн цалин | 148,643,900.0 | 148,514,138.23 |
| 210102 | Нэмэгдэл | 15,420,000.0 | 15,420,000.00 |
| 210104 | Урамшуулал | 30,157,200.0 | 30,157,200.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 31,534,800.0 | 31,534,800.00 |
| 2102 | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 28,501,600.0 | 28,501,600.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 19,409,900.0 | 19,409,900.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,347,900.0 | 2,347,900.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,798,300.0 | 1,798,300.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 449,600.0 | 449,600.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 4,495,900.0 | 4,495,900.00 |
| 2103 | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 18,810,300.0 | 18,808,486.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,917,800.0 | 2,917,486.00 |
| 210302 | Түлш, халаалт | 15,812,500.0 | 15,811,000.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 80,000.0 | 80,000.00 |
| 2104 | **Хангамж, бараа материалын зардал** | 45,188,400.0 | 45,188,320.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 3,400,000.0 | 3,400,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 38,200,000.0 | 38,200,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 821,500.0 | 821,420.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 150,000.0 | 150,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,616,900.0 | 2,616,900.00 |
| 2105 | **Нормативт зардал** | 800,000.0 | 800,000.00 |
| 210502 | Хоол, хүнс | 500,000.0 | 500,000.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 300,000.0 | 300,000.00 |
| 2106 | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 3,194,200.0 | 3,194,200.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 1,900,000.0 | 1,900,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 1,294,200.0 | 1,294,200.00 |
| 2107 | **Томилолт, зочны зардал** | 5,987,500.0 | 5,987,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 5,987,500.0 | 5,987,000.00 |
| 2108 | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 27,465,500.0 | 27,497,482.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 27,000,000.0 | 27,032,062.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 116,200.0 | 116,188.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 108,900.0 | 108,900.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 220,000.0 | 220,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 20,400.0 | 20,332.00 |
| 2109 | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 2,600,000.0 | 2,563,500.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 2,600,000.0 | 2,563,500.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **358,303,400.0** | **358,166,726.23** |
| 1320 | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 358,303,400.0 | 358,166,726.23 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 358,303,400.0 | 358,166,726.23 |
| 132007 | Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих | - | - |
| 4 | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| 5 | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | - | |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | - | **12,331,783.0** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | - | 12,331,783.0 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | - | 12,331,685.00 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | - | 3,115,115.00 |
| 210101 | Үндсэн цалин | | 3,115,115.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | - | 236,670.00 |
| 210401 | Бичиг хэрэг | | |
| 210402 | Тээвэр, шатахуун | | 230,670.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | | 6,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | - | 1,760,000.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | | 1,700,000.00 |
| 210602 | Тавилга | | |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | | 60,000.00 |
| 210604 | Урсгал засвар | | |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | - | - |
| 210701 | Гадаад албан томилолт | | |
| 210702 | Дотоод албан томилолт | | |
| 210703 | Зочин төлөөлөгч хүлээн авах | | |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | - | 4,920,000.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | | 4,920,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | - | 2,299,900.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | | 2,299,900.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | | |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | - | 98.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | - | 98.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | | |
| 213405 | Төвлөрүүлэх шилжүүлэг | | 98.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | - | **12,331,783.0** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | - | 12,331,783.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | - | 12,331,783.00 |
| 131106 | Төсвийн урамшуулал | - | - |
| **4** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | - |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | - | - |

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Алтай сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.



Говь-Алтай аймаг дахь ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Аудитыг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Г.Энхдэлгэр гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор Ж.Бужинханд, аудитын менежер Д.Эрдэнэчимэг , дарга, тэргүүлэх аудитор Х.Түвшинбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Алтай сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төрийн аудитын газарт 2021 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 03/15 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Алтай сумын Засаг даргын тамгын газар нь Засаг даргын хууль тогтоомжоор олгогдсон бүрэн эрх үйл ажиллагааныхаа хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд нь цаг үеэ олсон, оновчтой зөвлөгөө, мэдээллээр хангаж бүх талын дэмжлэг үзүүлж, төрийн үйлчилгээг иргэдэд хүртээмжтэй чанарын өндөр түвшинд хүргэх чиг үүрэгтэй сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллага юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Алтай сумын Засаг даргын тамгын газар нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр үр дүнгийн тайлангийн нийт зардлаар сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.



Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газар

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны үр дүнгийн тайлангийн зардлын 540.0 сая төгрөгөөс 2 хувиар буюу 10.8 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувь буюу 8.0 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Алтай сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1.3 сая төгрөгөөр өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өглөг, эздийн өмчийн данс байхгүй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 339.4 сая төгрөг болж 29.3 сая төгрөгөөр буурсан нь 35.5 сая төгрөгийн бараа материал акталсантай холбоотой байна. Тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 64.2 сая төгрөгийн бараа материал бэлтгэж үйл ажиллагаандаа 64.2 сая төгрөгийн материалыг зарцуулжээ. Оны эцэст 339.4 сая төгрөгийн бараа материалын үлдэгдэлтэй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 2,489.3 сая төгрөг болж 127.8 сая төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 3.6 сая төгрөгийн хөрөнгө бэлтгэж, 246.9 сая төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүйгээр хүлээн авсантай холбоотой байна. Тайлант онд 68.8 сая төгрөгийн хөрөнгийг акталсан ба тайлант оны эцэст 2,489.3 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн үлдэгдэлтэй байна.

Авлага дансны үлдэгдэлд Бүрдмэл Алтай ХХК-с авахаар 40.0 сая төгрөгийн авлага бүртгэлтэй байна. Авлага барагдуулахаар хууль хяналтын байгууллагад хандсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 2,200.4 сая төгрөг болж 1.3 сая төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан бичилт хийгдээгүй ба тайлант оны хуримтлагдсан үр дүнгийн эцсийн үлдэгдэл 1,902.1 сая төгрөг болсон байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 358.3 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлснийг баталсан байна.

#### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсөв захирагчийн 1 хөтөлбөрийн хүрээнд 2 арга хэмжээг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр 358.3 сая төгрөгийн төсөв баталсан байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 358.3 сая төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 358.2 сая төгрөгийг зарцуулж 0.1 сая төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 358.2 сая төгрөг буюу 99.9 хувьтай байна. Зардал хэмнээгүй.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар 12.3 сая төгрөгийн санхүүжилт орж, урсгал зардалд 12.3 сая төгрөг зарцуулж тайлагнасан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав

## 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

## 3.8 Аудитын гол асуудал

Тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

## 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу тус байгууллагын 2021 оны шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хяналаа.

### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 134 мэдээллээс 125 мэдээллийг хугацаандаа мэдээлсэн ба хугацаа хоцроосон 9 мэдээлэл байна.

## 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 0.7 сая төгрөгийн төлбөрийн акт, 78.3 сая төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага, 28.6 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж хүргүүлснийг хэрэгжүүлсэн байна.

## 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар төсвийн хэмнэлтийн горимыг баримталж ажиллаж буй эсэхийг, мөн тээвэр шатахууны зарцуулалт, норм, бараа материалын тулгалтыг үзэх нь зүйтэй.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 532.4 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 10.6 сая төгрөгийн алдааг залруулж, 521.8 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 1 зөвлөмж өгсөн. МУЕА-т 1 асуудлаар санал уламжиллаа.

### 4.1 Залруулсан алдаа

Аудитын явцад тайлант хугацаанд шивүүлээгүй 1.9 сая төгрөгийн төлбөрийн баримтыг нөхөж шивүүлсэн.

### 4.2 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогоогүй.

### 4.3 Албан шаардлага

Батлагдсан төсвийг 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар төлөвлөж зарцуулаагүй нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1-т "үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах" заалттай нийцэхгүй бөгөөд нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүллээ.

Жилийн эцсийн тооллогоор 487.7 сая төгрөгийн хөрөнгийг тоолж баталгаажуулаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12.1-т "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна.", 12.2-т "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ":, 12.2.1.жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө;/, 20.2.6-т /эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;/, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72.4-т "комиссын хурлаар тооллогын үр дүнг хэлэлцэж, тооллогын бүртгэлийг баталгаажуулж, холбогдох акт, материалын хамт ерөнхий нягтлан бодогчид тусгай жагсаалтаар шилжүүлэн өгөх" заалттай нийцэхгүй бөгөөд нийцсэн бөгөөд зохистой байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүллээ.

Батлагдсан орон тооноос 1 орон тоогоор илүү үйл ажиллагаа явуулж байгаа нь Засгийн газрын 2009 оны 13 дугаар тогтоол "Сумын Засаг даргын тамгын газрын орон тооны хязгаарыг тогтоох тухай" нийцэхгүй бөгөөд нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүллээ.

Татварын тодорхойлолтоор 25.2 сая төгрөгийн зөрүү тооцоо татварын цахим системд бүртгэлтэй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.1-т "Аж ахуйн бүх ажил, гүйлгээ", 14.4.2-т "Бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага", 14.4.3-т "Бүх өр төлбөр" заалттай нийцэхгүй бөгөөд нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүллээ.

Гэрээний хугацаа дууссан байхад 11 толгой 6.1 сая төгрөгийн малыг дараагийн малчин өрхөд хүлээлгэн өгөөгүй байгаа нь “Малчидтай байгуулсан малжуулах гэрээ” нийцэхгүй бөгөөд нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүллээ.

Түлш халаалтын зардлаас бэлтгэсэн нүүрснээс ажилчдад 0.5 сая төгрөгийн нүүрсийг түлшний хөнгөлөлтөөр олгосон нь Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаал "Эдийн

засгийн ангилал ашиглах заавар"-тай нийцэхгүй бөгөөд нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүллээ.

Хамтын сангийн хуримтлалд зориулж ажилчдын цалингаас 2.4 сая төгрөгийг суутгасан нь Хөдөлмөрийн тухай хуулийн 119 дүгээр зүйлийн 119.1-т "Ажил олгогч ажилтны цалин хөлсийг бүрэн хэмжээгээр нь олгох бөгөөд дараах тохиолдолд суутгал хийж болно:" заалттай нийцэхгүй бөгөөд нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүллээ

### 4.4 Зөвлөмж

Аудитаар илэрсэн зөрчилд 1 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. ***Мөнгөн хөрөнгийн данстай холбоотой асуудал***

1.1. Илрүүлэлт: Шилэн дансны цахим хуудсанд цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 104.0 төгрөгийн мөнгөн гүйлгээг мэдээлээгүй.

1.2. Өгсөн зөвлөмж: Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах.

### 4.5 Санал уламжлах

Аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2021 оны 94 дүгээр тогтоолоор Алтай сумын ЗДТГ-т бүртгэлтэй 35.6 сая төгрөгийн үнэтэй, 7.4 сая төгрөгийн үлдэгдэл өртөгтэй автомашины худалдах үнийг 2.5 сая төгрөгөөр тогтоон эзэмшигчид нь худалдахаар тогтоосны үндсэн дээр ЗДТГ-ын данснаас хассан байна.

Энэ нь Төрийн аудитын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1-д заасаны дагуу гэмт хэргийн шинж чанартай байж болзошгүй гэж үзээд Монгол улсын Ерөнхий аудиторт уламжилж байна.

## 2. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

| д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | Алтай сумын Засаг даргын тамгын газар | 10 | 532.4 | 2 | 10.6 | | | 7 | 521.8 | 1 | 0 |



Говь-Алтай аймаг дахь ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР